



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 26 өдөр


Дугаар 249

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалт, Засгийн газрын “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 1995 оны 101 дүгээр тогтоолын 5 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам”-ыг нэгдүгээр, “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх төлбөрийн хэмжээг тооцох аргачлал”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтийг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/-т тус тус даалгасугай.



САЙД

Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 26 өдрийн
24.9 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эрүүл мэндийн салбарт ашиглаж байгаа, Монгол улсын хилээр оруулж ирсэн эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Энэхүү журмыг улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэгч аж ахуй нэгж, иргэн болон шалгалт тохируулга хийх итгэмжлэгдсэн байгууллага дагаж мөрдөх бөгөөд тэдгээрийн хоорондын харилцааг гэрээний үндсэн дээр зохицуулна.

1.3 Монгол улсын хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, аюулгүй, найдвартай үзүүлэхэд оршино.

1.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэмжлийн нэгдмэл байдал, цахилгааны аюулгүй, хэвийн, найдвартай ажиллагааг хангахад журмын гол зорилго оршино.

1.5 Энэхүү журам нь Эрүүл мэндийн тухай хууль, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомж, олон улсын болон хүчин төгөлдөр бусад стандартыг дагаж мөрдөнө.

Хоёр. Тодорхойлолт, нэр томъёо

2.1 Энэжурмандхэрэглэсэндараахьнэртомъёогдордурдсанутгааройлгоно:

2.1.1 “Эмнэлгийн тоног төхөөрөмж” гэж хүний бие махбодийн бүтэц, үйл ажиллагаа, өвчин, эмгэг, согогийг оношлох, эмчлэх, сэргээн засах, хянах зориулалтаар бүтээгдсэн бие даасан ажиллагаа бүхий зүйлийг;

2.1.2 “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үйл ажиллагаа” гэж эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор тусгай зориулалтын симулятор, анализаторын тусламжтайгаар тухайн тоног төхөөрөмжийн нийтлэг болон тусгай үзүүлэлт тус бүрийг олон улсын болон үндэсний стандартын дагуу хэмжилт хийж, шаардлагад нийцэж буй тоног төхөөрөмжийг баталгаажуулан гэрчилгээ олгох үйл ажиллагааг;

2.1.3 “Шалгалт тохируулга” гэж эмнэлгийн тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтэд хэмжилт хийж, олон улсын стандартын дагуу алдааны утгыг тогтоох үйл ажиллагааг;

2.1.4 “Баталгаажуулалт” гэж тухайн эмнэлгийн тоног төхөөрөмж нь стандартаар тогтоосон шаардлагад нийцэж байгааг эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагаас тогтоож, батлах үйл ажиллагааг;

2.1.5 “Цахилгааны аюулгүй байдал” гэж олон улсын IEC 60601-1 стандартыг

- хангасан эмнэлгийн тоног төхөөрөмж нь үйлчлүүлэгч болон хэрэглэгчийг цахилгааны аюулаас бүрэн хамгаалсныг;
- 2.1.6 “Анализатор” гэж эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийхэд зориулагдсан, тухайн эмнэлгийн тоног төхөөрөмжөөс гарч буй дохиог бүртгэн авч мэдээлэх хэмжилтийн тоног төхөөрөмжийг;
- 2.1.7 “Симулятор” гэж эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийхэд зориулагдсан, дохиог тухайн эмнэлгийн тоног төхөөрөмжид өгөх хэмжилтийн тоног төхөөрөмжийг;
- 2.1.8 “Нийтлэг үзүүлэлт” гэж тухайн эмнэлгийн тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийн цахилгаан хамгаалалт, чадал, гүйдэл, давтамж зэрэг цахилгаан аюулгүй байдлын үзүүлэлтүүдийг;
- 2.1.9 “Тусгай үзүүлэлт” гэж тухайн эмнэлгийн тоног төхөөрөмжийн ноошилгоо, эмчилгээний онцлогт хамаарсан техник үзүүлэлтийг;

Гурав. Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх үйл ажиллагаа

3.1 Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн тоног төхөөрөмж ханган нийлүүлэгч аж ахуй нэгж, иргэн (цаашид хүсэлт гаргагч гэх) нь шалгалт тохируулга хийх итгэмжлэгдсэн байгууллага (цаашид гүйцэтгэгч гэх)-д шалгалт тохируулга хийлгэх эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээлэл болон хүсэлтээ албан бичгээр хүргэнэ.

3.2 Албан тоотоор ирүүлсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийг энэхүү журмын 5.3 дахь заалтыг үндэслэн шалгалт тохируулга хийх ажилтан ангилж, бүртгэнэ.

3.3 Гүйцэтгэгч нь эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх хуваарь гарган үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, хүсэлт гаргагчид хуваарийг хүргэнэ.

3.4 Хуваарийн дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн нийтлэг болон тусгай үзүүлэлтэд шалгалт тохируулга хийнэ.

3.5 Гүйцэтгэгч нь стандартын шаардлага бүрэн хангасан эмнэлгийн тоног төхөөрөмжид дардас дарж, гэрчилгээ олгоно.

3.6 Тухайн хүсэлт гаргагчид стандартын шаардлага хангаагүй эмнэлгийн тоног төхөөрөмжийн тухай мэдэгдэл хүргэж, засвар үйлчилгээний зөвлөмж өгнө.

3.7 Мэдэгдлийн дагуу хүсэлт гаргагч байгууллагын инженер техникийн ажилтан засвар үйлчилгээг хийж, дахин шалгалт тохируулгад хамруулна.

3.8 Гүйцэтгэгч нь шалгалт тохируулгын ажлын явцад хийсэн протоколыг архивлана.

3.9 Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулгын үйл ажиллагааны тайланг холбогдох дээд шатны болон хяналтын байгууллагад мэдээлнэ.

Дөрөв. Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх үйл ажиллагаанд тавигдах шаардлага

4.1 Шалгалт тохируулга хийх байгууллага, нэгж нь итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллага байна.

4.2 Шалгалт тохируулга хийх мэргэжилтэн нь энэ чиглэлээр тусгай сургалтанд хамрагдаж, итгэмжлэлийн байгууллагаас үйл ажиллагаа эрхлэх эрх авсан, эмнэлгийн тоног төхөөрөмжийн дадлага, туршлагатай инженер байна.

4.3 Зөвхөн итгэмжлэгдсэн хүрээнд тусгагдсан төрлөөр шалгалт тохируулгын ажлыг гүйцэтгэнэ.

4.4 Шалгалт тохируулга хийх байгууллага, нэгжийн техникийн хүчин чадал нэмэгдэн итгэмжлэлийн хүрээ өргөжих тохиолдолд шалгалт тохируулгад хамрагдах эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр болон хоорондын хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулна.

4.5 Шалгалт тохируулгын үйл ажиллагааг эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх зориулалт бүхий олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар баталгаажсан симулятор болон анализатораар хийнэ.

4.6 Шалгалт тохируулга хийх симулятор болон анализаторыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагад тогтоосон хугацаанд баталгаажуулсан байна.

4.7 Шалгалт тохируулгыг олон улсын болон үндэсний стандарт, норматив, техникийн баримт бичгээр тогтоогдсон дүрэм, журмаар мөрдөнө.

4.8 Шалгалт тохируулгын хоорондын хугацааг(хүснэгт 4)-ийн дагуу үнэн зөв тодорхойлно.

4.9 Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх үйл ажиллагааг гэрээгээр зохицуулна.

4.10 Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх төлбөрийн хэмжээг тооцох аргачлал, жишиг үнийг баримтална.

4.11 Эрүүл мэндийн байгууллагууд нь эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх зардал, шалгалт тохируулга хийх нэгж нь шалгалт тохируулга хийх симулятор болон анализаторыг баталгаажуулалтын зардлыг тооцож, байгууллагынхаа жил бүрийн төсөвт тусгасан байна.

4.12 Шалгалт тохируулгын үйл ажиллагааг ариутгал халдваргүйжүүлэлт, хөдөлмөр хамгааллын нөхцлийг бүрдүүлсэн, стандартын шаардлага хангасан цахилгаан үүсгүүр, газардуулгатай орчинд хийж гүйцэтгэнэ.

4.13 Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, инженер техникийн ажилтнууд нь тоног төхөөрөмжийг шалгалт тохируулгын үйл ажиллагаанд хамруулах төлөвлөлт, гүйцэтгэлийг хариуцана.

4.14 Эрүүл мэндийн байгууллагууд шалгалт тохируулга хамруулах тоног төхөөрөмжийн дагалдах хэрэгсэл, техник ашиглалтын паспорт, ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилга болон бусад баримт бичгийг бүрдүүлж, шалгалт тохируулга хийх нэгжид хүргүүлсэн байна.

4.15 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үр дүнг үйл ажиллагааг баримтжуулж, эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгнө.

Тав. Хяналт, хариуцлага

5.1 Шалгалт тохируулгын үйл ажиллагааны хяналтыг холбогдох дээд шатны болон хяналтын байгууллага хийж гүйцэтгэнэ.

5.2 Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдоххууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 26 өдрийн
249 дугаар тушаалын 2 дүгээр
хавсралт

ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА ХИЙХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх төлбөрийн хэмжээг тооцоход энэхүү аргачлалыг мөрдөнө.

1.2 Төлбөрийн хэмжээг тооцох зорилго нь тухайн нэгж эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийхэд гарах бодит зардлыг үнэн зөв гаргахад оршино.

Хоёр. Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх төлбөрийн хэмжээг тооцох

2.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх төлбөрийн хэмжээг тооцоходоо дараах өгөгдлүүдийг ашиглана. Үүнд:

- Симулятор болон анализаторын үндсэн өртөг;
- Симулятор болон анализаторын жил бүр үйлдвэрлэгч рүү явуулж баталгаажуулалт хийх өртөг;
- Шалгалт тохируулгын гэрчилгээний өртөг;
- Симулятор болон анализаторын насжилт;
- Шалгалт тохируулга хийх мэргэжилтний сарын дундаж цалин;
- Нэгж тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийх хугацааны норм;

2.2 Эмнэлгийн нэгж тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх төлбөрийн хэмжээг дараах томъёогоор тооцоолно.

$$T = (X_T * X_\Theta) + \Theta_H$$

Үүнд:

T - Нэгж тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх төлбөр

X_T - Нэгж тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх нийт хэмжилтийн тоо

X_Θ - Нэг хэмжилтийн ногдох хөдөлмөрийн хөлс

Θ_H - Нэгж тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх эдийн засгийн нийт өртөг

$$\Theta_H = \Theta_x^1 + \Theta_x^2 + \dots + \Theta_x^n + \Theta_m$$

Θ_x^1 - Эхний симулятор болон анализатораар эмнэлгийн нэгж тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийхэд ногдох өртөг

Θ_x^2 - Хоёр дахь симулятор болон анализатораар эмнэлгийн нэгж тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийхэд ногдох өртөг

Θ_m - Шалгалт тохируулгын гэрчилгээний үнэ

$$\Theta_x^1 = \frac{(\Theta_e + \Theta_6) * x}{T_x}$$

Θ_6 - Симулятор болон анализаторын өөрийн өртөг

t_a - Симулятор болон анализаторын нийт ашиглалтын хугацаа

Θ_6 - Симулятор болон анализаторыг жилд нэг удаа үйлдвэрлэгч рүү илгээн баталгаажуулалт хийлгэхэд шаардагдах зардал

T_x - Нэг жилд шалгалт тохируулга хийх тоног төхөөрөмжийн тоо

x - Симулятор болон анализаторын тоо

$$T_x = \frac{T_n * \Gamma}{100\%}$$

T_n - Тухайн шалгалт тохируулга хийх тоног төхөөрөмжийн нийт тоо

Γ - Ажиллах хүний нөөцийн бололцоог тооцсон гүйцэтгэлийн хувь

$$\Gamma = \frac{(X_a * \zeta_a * n) * 100}{\Sigma T_n * t_x^d}$$

X_a - Нэг жилд ажиллах хоног

ζ_a - Нэг хоногт ажиллах цаг

n - Шалгалт тохируулга хийх инженер техникийн ажилтны тоо

ΣT_n - Нийт шалгалт тохируулгах тоног төхөөрөмжийн тоо

t_x^d - Шалгалт тохируулга хийх дундаж хугацаа

$$X_\Theta = \frac{H_x}{X_m}$$

H_x - Шалгалт тохируулга хийх хөдөлмөрийн хөлс

X_m - Нэгж тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх нийт хэмжилтийн тоо

$$H_x = K_1 * \zeta_w * (1 + K_2) * t_x * n$$

K_1 - нэг цагийн хөдөлмөрийн хөлсөнд ногдох коэффициент ба 0,006-тай тэнцэнэ.

ζ_w - Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх мэргэжилтний сарын үндсэн цалингийн дундаж (төгрөг)

K_2 - Хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн хөлсөнд ногдуулах албан татварын хэмжээг тооцсон коэффициент ба 0,11-тэй тэнцэнэ.

t_x - нэгж эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх хугацааны норм (цаг)

n - Шалгалт тохируулга хийх инженер техникийн ажилтны тоо

2.3 Дээрх аргачлалаар төлбөрийн хэмжээг тооцоолохдоо шалгалт тохируулга хийх үзүүлэлтийн жагсаалт (Хүснэгт 1), шалгалт тохируулга хийх симулятор болон анализаторын ашиглалтын хугацаа (Хүснэгт 2), шалгалт тохируулга хийх хэмжилтийн тоо болон хугацаа (Хүснэгт 3) зэрэг өгөгдлүүдийг тус тус ашиглана.

2.4 Шинэ загварын симулятор болон анализаторыг хэрэглэж эхлэх үед болон эдийн засгийн үзүүлэлт мэдэгдэхүйцээр өссөн үед шалгалт тохируулга хийх төлбөрийн тооцоог дахин хийнэ.

Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх техник үзүүлэлтийн задаргаа

№	Шалгалт тохируулга хийх тоног төхөөрөмжийн ангилал	Шалгалт тохируулга хийх үзүүлэлт
Нийтлэг үзүүлэлтийн шалгалт тохируулга		
1	Цахилгааны аюулгүй байдлыг хэмжих (Бүх цахилгаан тоног төхөөрөмжийн цахилгааны аюулгүй байдлыг хэмжинэ)	- Оролтын чадал
		- Гүйдэл
		- Хүчдэл
		- Өвчтөний алдагдал гүйдэл
		- Гадаргуун алдагдал гүйдэл
		- Газардуулгын алдагдал гүйдэл
		- Хэмжлийн алдагдал гүйдэл
		- Газардуулгын эсэргүүцэл
Тусгай үзүүлэлтийн шалгалт тохируулга		
2	Амьсгалын аппарат болон амьсгал дэмжих бүх төрлийн аппарат	- Багадаралт
		- Өндөрдаралт
		- Амьсгалын хүрээндэхь даралт
		- Үргэлжилсэн урсгал
		- Эзлэхүүнд урсгал
		- Өвчтөнд очих агаарын температурыг хэмжих
		- Өвчтөнд очих агаарын температурыг хязгаарлах анхааруулах дохиоллын системийг шалгах
		- Хүчилтөрөгчийн концентрацыг хэмжих
3	Дефибриллятор	- Тасралтгүй ажиллагааны шалгалт
		- Гаралтын энерги
		- ЭКГ-ны долгион
		- Pacemaker-ын ачаалалтай үеийн сонгон шалгах
		- Pacemaker-ын хэмжилт
4	Дуслын автомат шахуурга	- Хэрэгцээт болон асинхрон модийн хэмжилт
		- Урсгалын хурдыг тодорхойлох
		- Эзлэхүүнийг тодорхойлох
		- PCA bolus/нэмэлт урсгалыг тодорхойлох
		- Даралтыг тодорхойлох
		Дуслын нарийвчлал тогтоох шалгалт
		Анхааруулах дууны чадлыг хэмжих
5	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	- Хазайлт, хийн бөмбөлгийн шалгалт
		- Хэвийн, синус болон хэмт долгион
		- Pacemaker-ын долгион
		- Зүрхний хэмалдалт
		- ЭКГ-ны үзүүлэлтийн тест
		- ЭКГ artifact
6	Мэдээгүйжүүлгийн аппарат	- Багадаралт
		- Өндөрдаралт
		- Амьсгалын хүрээндэхь даралт

		- Үргэлжилсэнурсгал
		- Эзлэхүүнтэйурсгал
		- Хүчилтөрөгчийн хэмжээг тодорхойлох
7	Нярайн дулаацуулах ширээ	- Температур
		- Шуугиан
8	Няраининкубатор	- Температур
		- Харьцангуйчийгшил
		- Агаарынурсгал
		- Шуугиан
		- Инкубатордоторхүчилтөрөгчийнхэмжээ
9	Өвчтөнийхяналтын монитор	- Хэвийн, синусболонхэмтдолгион
		- Pacemaker-ындолгион
		- Зүрхнийхэмалдалт
		- ЭКГ-ныүзүүлэлтийнтест
		- ЭКГ artifact
		- Шуудцусныдаралт
		- Амьсгал
		- Температур
		- Зүрхнийгаралт
		- Захынсудасдахь хүчилтөрөгчийнхэмжээ
		- Шуудбусцусныдаралт
10	Компьютерт томографын аппарат / Рентген аппарат	- kV – Хүчдэл
		- Dose/Exposure
		- Dose/Exposure Rate
		- Exposure Time - Radiographic Modes
		- Elapsed Time - Fluoro Modes
		- Average Pulse Rate - Pulsed Fluoro
		- Average Pulse Width - Pulsed Fluoro
		- HVL (Half Value Layer)
		- mAs
		- Фантом
		- Дүрсийнчанарыгшалгах
11	Тариурын автомат шахуурга	- Урсгалынхурдыгтодорхойлох
		- Эзлэхүүнийгтодорхойлох
		- PCA bolus/нэмэлтурсгалыгтодорхойлох
		- Даралтыгтодорхойлох
		- Дуслын нарийвчлал тогтоох шалгалт
		- Анхааруулах дууны чадлыг хэмжих
		- Хазайлт, хийн бөмбөлгийн шалгалт
12	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	- Хүчилтөрөгчийн концентрацыг хэмжих
		- Аппаратаас гарч буй дуун хэмжээг хэмжих
		- Урсгал хэмжих
13	Хэт авиан оношилгооны аппарат	- Дүрсийнчанарыгшалгах
14	Цахилгаан мэс заслын аппарат	- RMS зурвасынөргөн
		- Намдавамжийншүүлтүүр
		- Гүйдэл
		- Ачаалалтайүеийнэсэргүүцэл
		- Хөлудирдлагынгаралт

Шалгалт тохируулга хийх симулятор болон анализаторын ашиглалтын хугацаа

№	Симулятор болон анализаторын нэр	Нийт ашиглалтын хугацаа / t_a / -жилээр
Анализатор		
1	Дефибрилляторыншалгахтестанализатор	10
2	Дуслынболонтариурынавтоматшахуургалгаханализатор	10
3	Няраининкубаторшалгаханализатор	10
4	Рентгенболонкомпьютерт томографийнаппаратыгшалгахтестанализатор	10
5	Хийнурсгалхэмжигчанализатор	10
6	Хүчилтөрөгчийнагууламжийнхэмжээгтодорхойлоханализатор	5
7	Цахилгааныаюулгүйбайдлыгшалгаханализатор	5
8	Цахилгаанмэсзаслынаппаратыг шалгаханализатор	10
Симулятор		
9	Өвчтөнийхяналтынмониторшалгахсимулятор	5
10	Хэтавианоношилгооныаппаратшалгахфантом	10

Хэмжилт хийх хүний тоо болон хугацаа

№	Шалгалт тохируулга хийх тоног төхөөрөмжийн нэр	Нийт хамрагдах тоног төхөөрөмжийн тоо T_n	Нэг жилд хамрагдах тоног төхөөрөмжийн тоо T_x	Хэмжилт хийх хүний тоо / n /	Хэмжилтийн хугацаа / t_x / - /цаг/
1	Амьсгалын аппарат	476	143	2	3
2	Дефибриллятор	265	80	2	2
3	Дуслын автомат шахуурга	577	173	2	4
4	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	439	132	2	2
5	Мэдээгүйжүүлгийн аппарат	166	100	2	3
6	Нярайн дулаацуулах ширээ	347	104	2	2
7	Няраининкубатор	213	64	2	3
8	Өвчтөнийхяналтынмонитор	1039	186	2	2
9	Рентген аппарат / Компьютерт томографийн аппарат	244	102	2	3
10	Тариурын автомат шахуурга	531	159	2	4
11	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	890	223	1	2
12	Хэт авиан оношилгооны аппарат	661	198	2	1
13	Цахилгаан аюулгүй байдлын хэмжилт	800	240	2	1
14	Цахилгаан мэс заслын аппарат	172	103	2	2

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын хоорондын хугацаа

№	Шалгалт тохируулга хийх эмнэлгийн тоног төхөөрөмжийн нэр	Шалгалт тохируулгын хоорондын хугацаа/жилд/
1	Амьсгалын аппарат	2 удаа
2	Дефибриллятор	2 удаа
3	Дуслын автомат шахуурга	1 удаа
4	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	1 удаа
5	Мэдээгүйжүүлгийн аппарат	2 удаа
6	Нярайн дулаацуулах ширээ	2 удаа
7	Нярайнинкубатор	1 удаа
8	Өвчтөнийхяналтынмонитор	1 удаа
9	Рентген аппарат / Компьютер томографийн аппарат	1 удаа
10	Тариурын автомат шахуурга	1 удаа
11	Хүчилтөрөгч өтгөрүүлэгч	1 удаа
12	Хэт авиан оношилгооны аппарат	1 удаа
13	Цахилгаан аюулгүй байдлын хэмжилт	1 удаа
14	Цахилгаан мэс заслын аппарат	2 удаа

“Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгад хамрагдах хоорондын хугацаа”-г тодорхойлохдоо эрсдэлд суурилсан үнэлэх аргачлалыг олон улсад түгээмэл хэрэглэгддэг, Америкийн нэгдсэн улсын Вермонтгийн их сургуулиас хэвлэж гаргасан “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалт” эмхэтгэлийг үндэслэнэ.